



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗОРИУЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН НИЙТЛЭГ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ



**НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛӨӨС ТАВИХ
ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2017 он**

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:		
Архангай аймаг дахь Төрийн аудитын газар		
Тэргүүлэх аудитор Д. Уламбаяр		
Аудитын менежер Т.Байгалмаа		
Аудитор Г.Цог-Эрдэнэ Х.Алтанчимэг		
2017 оны 12 дугаар сар		
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.		
www.audit.mn		
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу		
ХАЯГ: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот		
	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	2-4
	БҮЛЭГ 1. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРИМ ЗАРЦУУЛАЛТ УРСГАЛ ШИНЖТЭЙ БАЙНА.	5
	1.1. Засаг даргын нөөц хөрөнгийн ихэнх хувийг журмын 2.1.3 дахь заалтын хүрээнд зарцуулсан байна.	5
	1.2. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг журмын 3.1-д заасны дагуу ЗД-ын зөвлөлийн хурлын шийдвэрээр зарцуулахгүй байна.	5 6
	1.3. Засаг даргын нөөц хөрөнгийг аймгийн ИТХ-аар батлуулж ажилласан байна. .	7
	БҮЛЭГ 2. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХДАА АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЛИЙГ БҮРЭН ХАНГАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.	8
	2.1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн томоохон зардлын хувьд тооцоог СТСХ-ээр хянуулан холбогдох газар хэлтсээс санал авсан байна.	8 8-9
	2.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжигдэх зарим арга хэмжээг үе шатны ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжилтийг олгосон байна.	10-12
	2.3 Тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд ирүүлэхгүй байна.	
	2.4 Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах хэрэгтэй байна.	12-13
	ДҮГНЭЛТ.....	14
	ЗӨВЛӨМЖ.....	15
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	16
	ХАВСРАЛТУУД	17-19
	1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	
	2. ЗӨВЛӨМЖ	

Товчилсон үгийн жагсаалт

АРХ	АРХАНГАЙ АЙМАГ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
СТСХ	САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ЗДЗ	ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛ
АШБ	АНХАН ШАТНЫ БАРИМТ
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
ТЗУХ	ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Аудитын нэр: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын хэрэгжилт

Аудитын код: APX-/2017/05-НА

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт, гүйцэтгэлийг тайлагналт нь журам заавартай нийцэж байгаа эсэх, Аймгийн Засаг дарга зориулалтын дагуу санхүүжүүлж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулан аудитын дүнгээс орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт оршино. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, зориулалтын дагуу үнэн зөв зарцуулсан эсэх
- Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх

Аудитын хүрээ:

Аудитаар аймгийн Засаг дарга, ЗДТГазар, Засаг даргын зөвлөлийг хамруулж ЗДТГ, СТСХэлтсийн холбогдох албан тушаалтнуудаас 2017 оны санхүүгийн анхан шатны баримт материалууд, гүйцэтгэсэн ажлын тайланг хамруулан шалгалаа.

Аудитын шалгуур:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын удирдамж (АДБОУС 4000), нийцлийн аудитын түр журмыг ашиглан холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэргээр Тэргүүлэх аудиторовн баталсан аудитын төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хуультай нийцүүлэн гаргасан дүрэм, журам

- Сангийн сайдын 2012 оны 239 тогтоол /Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам/
- Сангийн сайдын 2015 оны 165 тогтоол /журамд нэмэлт оруулах тухай /
- Шилэн дансны тухай хууль

Аудитад тохиолдсон хүндрэл бэрхшээлийн талаар:

Аудитыг төлөвлөгөөнд заасан хугацааны дагуу 2017 оны 12 сарын 28-нд дуусгах ёстой байсан хэдий ч шалгагдагч байгууллагаас 9 сараас хойшхи баримт материалыг заасан хугацаанд ирүүлээгүйгээс шалтгаалан аудитын тайлан он дамжихад хүрлээ.

Үндсэн мэдээлэл

Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын үндэслэлд “Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон тухайн шатны Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө” гэж заасан байна.

2016 оны Засаг даргын нөөц сангийн хөрөнгө аймгийн ИТХ-аар анх 147.5 сая төгрөгөөр батлагдсан ба тодотголоор өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, өвс тэжээлийн аюулгүй нөөц бэлтгэх, цэрэг татлага, мал тооллогын зардал зарцуулахаар 389.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 534.7 сая төгрөгөөр батлагдсан байна. Батлагдсан төсвөөс гүйцэтгэлээр 470.9 сая төгрөгийг зарцуулж 63.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 53.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр санал гаргасан байна.

2017 оны Засаг даргын нөөц сангийн хөрөнгө аймгийн ИТХ-аар анх 147.5 сая төгрөгөөр батлагдсан бол 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 347.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд зориулж 400.8 сая төгрөгийн дэмжлэг хувиарлагдаж ирснийг ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд хувиарлан 748.3 сая төгрөгөөр баталсан байна. 2017 оны төсвийг өмнөх онтой харьцуулахад 28.1 хувиар илүү батлагдсан байна.

БҮЛЭГ 1.

ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРИМ ЗАРЦУУЛАЛТ УРСГАЛ ШИНЖТЭЙ БАЙНА.

1.1. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ИХЭНХ ХУВИЙГ ЖУРМЫН 2.1.3 ДАХЬ ЗААЛТЫН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад нийтдээ 17 зардлын зүйлээр **585.3** сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт-1

№	Гадаад аялал, визний үнэ	Шагналын зардал	Гарын бэлэг	Хэвлэлийн зардал	Шатахууны зардал	Засаг даргын жуух, буцалтгүй тусламж	буудал хоолны зардал	Замын зардал	Телевиз, нэвтрүүлэг, сэтгүүл, сонины зардал	Томилолтын зардал	байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	Ажлын зураг, төсвийн үнэ	Сургалт, семинарын зардал	Мөнгөн аяганд	Бусад бараа материал	Өвөлжилтийн бэлтгэл	татвар 10%	Нийт зардлын дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
Мөнгөн дүн	12.0	30.2	3.4	5.1	9.2	35.2	39.6	1.1	28.2	10.0	51.4	4.6	2.0	16.7	64.4	269.4	2.8	585.3
Нийт зардалд эзлэх хувь	2.1	5.2	0.6	0.9	1.6	6.0	6.8	0.2	4.8	1.7	8.8	0.8	0.3	2.9	11.0	46.0	0.5	100.0

Зарцуулалтыг Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамтай нийцүүлвэл 2.1.1¹ заалтын хүрээнд 12 ажил гүйлгээгээр **290.3** сая төгрөгийн 2.1.3² дахь заалтын хүрээнд 320 ажил гүйлгээгээр **295.0** сая төгрөгийг тус тус зарцуулсан бол 2.1.2³ дэх заалтын хүрээнд ажил гүйлгээ гараагүй байна. 2.1.3 дахь заалтын хүрээнд зарцуулсан ажил гүйлгээг харахад урсгал арга хэмжээнд ихэвчлэн зарцуулсан байна. Үүнд дээрх хүснэгтэд дэх зардлыг нэгтгэж харахад зочид төлөөлөгчид хүлээн авах, байршуулах зардалд **6.8** хувь буюу **39.7** сая төгрөгийг, шагнал, гарын бэлэг, мөнгөн аяга худалдан авах зардалд **8.7** хувь буюу **50.3** сая төгрөгийг, томилолт, шатахуун, замын зардалд **3.5** хувь буюу **20.3** сая төгрөгийг, гадаад аялалын зардалд **2.1** хувь буюу **12.0** сая төгрөгийг, бусад бараа материалын зардалд **11** хувь буюу **64.4** сая төгрөгийг, байгууллагын хэвийн үйл

¹ 2.1.1. Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;

² 2.1.3. Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх.

³ 2.1.2. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;

ажиллагааг хангах зардалд **8.8** хувь буюу **51.3** сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Иймд засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг урсгал зардалд зарцуулахгүй байхад анхаарч ажиллах хэрэгтэй байна.

1.2. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЖУРМЫН 3.1-Д ЗААСНЫ ДАГУУ ЗД-ЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭР ЗАРЦУУЛАХГҮЙ БАЙНА.

Аймгийн засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн а/03 дугаарт захирамжаар засаг даргын дэргэдэх зөвлөлийг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Тус зөвлөл нь 2017 оны тухайд нөөц хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор 02 дугаар сарын 14-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар 22.0 сая төгрөгийн 2 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэснээс өөрөөр нөөц хөрөнгөтэй холбоотой, хөрөнгө зарцуулах талаар хуралдаагүй, шийдвэр гаргаагүй байна. Мөн тус өдрийн хуралдаанаар “...нөөц хөрөнгөөс зардал гаргах тухай бүрд ЗДЗөвлөл хуралдах боломжгүй тул нөөц хөрөнгийг зарцуулах захирамжийн төсөл боловсруулахдаа санал авах хуудсаар удирдлагуудад танилцуулж гарын үсэг зуруулж байх мөн СТСХ-ийн даргаар заавал хянуулсан байх...”-аар шийдвэрлэсэн нь журмын 3.1 дэх заалттай нийцэхгүй байна. Уг шийдвэрийн хүрээнд нөөц хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор **153** захирамжийн төсөл зөвлөлийн гишүүдээр болон СТСХ-ийн даргаар хянагдаж, саналыг авч ажиллажээ.

/Аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтсээс захирамжийн төслийг боловсруулахад танилцах хуудас болон санал авах хуудсыг бөглүүлэн захирамжийн дугаар олголтын үед гарын үсэг болон саналыг хянаж танилцан эцсийн байдлаар баталгаажуулан огноо, дугаар олгосон байна./

/Хүснэгт-2/

Засаг даргын Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж захирамжаар зарцуулсан нөөц хөрөнгийн судалгаа

№	Сар	Захирамжийн		Үүнээс: Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн		Үүнээс: Засаг даргын захирамжийн төсөл танилцуулах санал авах хуудсаар	
		Тоо	Мөнгөн дүн /сая. Төг/	Тоо	Мөнгөн дүн /сая. Төг/	Тоо	Мөнгөн дүн /сая. Төг/
1	1	6	9.4	-	-	6	9.4
2	2	6	28.1	2	22.0	4	6.1
3	3	12	27.7	-	-	12	27.7
4	4	4	5.4	-	-	4	5.4
5	5	20	24.1	-	-	20	24.1
6	6	16	16.2	-	-	16	16.2
7	7	17	59.6	-	-	17	59.6
8	8						
9	9	17	74.6	-	-	17	74.6
10	10	21	51.4			21	51.4
11	11	8	106.8			8	106.8
12	12	26	193.9			26	193.9
Нийт дүн		153	597.2	2	22	151	575.2

Хүснэгтээс харахад ЗДНХ-ийг зарцуулахаар гарч буй захирамжийн төсөлд зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж танилцаж байгаа хэдий ч гарсан захирамжийн боловсруулалтыг харахад **хууль эрх зүйн үндэслэл буруу, эх үүсвэр зарцуулалтын утгаас зөрөх зэрэг дутагдлууд нилээд ажиглагдсан нь түүнд тавих хяналт хангалтгүй** байгааг харуулж байна.

Жишээлбэл: Өвсний санхүүжилт олгох, Малын халдварт өвчинтэй тэмцэх асуудал, Гамшиг ослын улмаас учирсан гэмтэл хохиролыг арилгах, сэргээн босгох зэрэг ажлын захирамжууд бүгд журмын 2.1.3 дахь заалт буюу засаг даргын хуулиар хүлээсэн бүрэн эрхийг үндэслэсэн байна. Зүй нь журмын 2.1.1 дэх заалтыг үндэслэх нь зохимжтой байсан.

Мөн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг харахад сангийн хөрөнгийн эх үүсвэр түүний бүрдэлд, зарцуулалт, үлдэгдэл зэргийг хэрхэн хянаж, цаашид хэрхэн зарцуулах гэх мэт асуудлыг огт хэлэлцээгүй зөвхөн тухайн хугацаанд гарсан зарцуулалтыг сонссоноос өөрөөр ямар нэгэн асуудал яригдаагүй байгаа нь сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Иймд Засаг даргын зөвлөл тухайн сар эсвэл улирлаар нөөц сан зарцуулахтай холбоотой гарах захирамжийн төслийг хэлэлцэж, **шийдвэр гаргадаг байх** нь журмын заалттай нийцэх ба түүнд тавих хяналт сайжрах болно.

1.3. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙГ АЙМГИЙН ИТХ-ААР БАТЛУУЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

2017 оны Засаг даргын нөөц сангийн хөрөнгө аймгийн ИТХ-аар анх 147.5 сая төгрөгөөр батлагдсан ба аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолоор **347.5** сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд зориулж **400.8** сая төгрөгийн дэмжлэг хувиарлагдаж ирснийг ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд хувиарлан **748.3** сая төгрөгөөр баталсан байна. Засаг даргын нөөц хөрөнгийг өмнөх онтой харьцуулбал **213.7** сая төгрөгөөр нэмэгдэж баталсан нь Хүнс хөдөө аж ахуйн яамнаас өвөлжилттэй холбоотойгоор санхүүжилт нэмэгдсэн байна. Нөөц хөрөнгийн батлагдсан төсвийг 2016, 2017 оноор харуулбал:

/Хүснэгт-3/

Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсөв сүүлийн хоёр оноор харьцуулбал:

№	Тайлант он	Тухайн оны төсөв батлах тухай		Аймгийн тодотгосон төсвөөр					
		АИТХ-ын тогтоолын огноо, дугаар, утга	Батлагдсан дүн / мянган төгрөг/	АИТХ-ын тогтоолын огноо, дугаар	нэмэгдүүлсэн дүн / мянган төгрөг/	Батлагдсан дүн / мянган төгрөг/	АИТХ-ын тогтоолын огноо, дугаар	нэмэгдүүлсэн дүн / мянган төгрөг/	Батлагдсан дүн / мянган төгрөг/
1	2016	-	152.0	2016.06.02-ны өдрийн 06 дугаарт тогтоол	216.3	368.3	2016.09.30-ны өдрийн 05 дугаарт тогтоол	166.3	534.6

2	2017	2016.12.04- ний өдрийн 11 дугаарт тогтоол	147.5	2017.04.26- ны өдрийн 05 дугаарт тогтоол	200.0	347.5	2017.11.15- ны өдрийн 05 дугаарт тогтоол	400.8	748.3
---	------	--	-------	---	-------	-------	---	-------	-------

Нийт батлагдсан төсвөөс 585.3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 163.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх үлдэгдлийг ИТХ-аар батлуулсан дүнтэй харьцуулахад журмын 2.3⁴-дахь заалттай нийцэхгүй буюу тогтоосон хувиас 8.3 хувиар дутуу үлдэгдлийг оны эцэст төвлөрүүлсэн бөгөөд 2018 онд дахин энэ мөнгийг ИТХ-аар батлуулж зарцуулах ёстой. 2017 оны тухайд Засаг даргын нөөц хөрөнгийг холбогдох хууль журмын хүрээнд ИТХ-аар батлуулсан байна.

Дүгнэлт:

Засаг даргын нөөц хөрөнгийг журамд заасны дагуу аймгийн ИТХ-аар батлуулж, зориулалтын дагуу зарцуулсан боловч урсгал шинжтэй зардалд зарцуулж байгаад засаг даргын дэргэдэх зөвлөл хяналтыг хангалтгүй тавьж ажиллаж байна.

Зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг урсгал зардалд зарцуулахгүй байхад анхаарч журмын 3.1-д заасан заалтыг хэрэгжүүлж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2

ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХДАА АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЛИЙГ БҮРЭН ХАНГАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

2.1. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГИЙН ТОМООХОН ЗАРДЛЫН ХУВЬД ТООЦООГ СТСХ-ЭЭР ХЯНУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗАР ХЭЛТСЭЭС САНАЛ АВСАН БАЙНА.

Аймгийн ЗДТГ Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахтай холбоотойгоор СТСХ-ээр санхүүжилтийн тооцоо судалгааг хянуулж, холбогдох газар хэлтсээс санал авч засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ёстой. Гэтэл 2017 онд Засаг даргын нөөц хөрөнгийн **22.0** сая төгрөгийг зарцуулах **2** захирамжийн төслийг Засаг даргын

⁴ 2.3. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана. /СС-ын 2015 оны 165-р тушаалаар нэмсэн/

зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн, **575.2** сая төгрөгийг зарцуулах **151** захирамжийн төслийг хяналтын хуудсаар хянуулж санал авсан байна.

Харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр **51.4** сая төгрөг, баяр наадмыг зохион байгуулахтай холбогдсон **26.4** сая төгрөг, мөн алдарт малчид, уяачид, фермерийг шалгаруулах чиглэлээр **22.0** сая төгрөг буюу нийт **99.8** сая төгрөгийн томоохон төсвийн зардлын тооцоог журмын 4.2⁵ дахь заалтын дагуу аймгийн СТСХэлтсээр хянуулан, саналыг авч захирамжийг гаргуулж ажилласан байна. Цаашид гарах захирамж бүрт санхүүжилтийг Санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулж ажиллах нь зүйтэй байна.

2.2. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС САНХҮҮЖИГДЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ НЬ УЯЛДУУЛАН САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОСОН БАЙНА.

Журмын 4.3⁶ дахь заалтын хүрээнд засаг даргын нөөц сангаас гарч буй томоохон арга хэмжээнүүдийн ажлын нөхцөл онцлог, явц зэрэгтэй уялдуулан санхүүжилтийг үе шаттайгаар олгох ёстой. Гэвч 2017 оны тухайд тийм томоохон төсөл арга хэмжээнд зориулж санхүүжилт гаргаагүй, бусад ихэнх тохиолдолд нэхэмжилсэн дүнгээр санхүүжилтийг олгосон байна. Харин дараах арга хэмжээний хувьд ажлын онцлог, нөхцөл, гүйцэтгэлтэй уялдуулан үе шаттай олгосон байна. Үүнд:

1.Засаг даргаас Орон нутгийн сонин, телевизүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж, ажлын гүйцэтгэлийг харгалзан 18.5 сая төгрөгийг журмын 2.1.3 дахь заалтаас,

2. Цэцэрлэг сумын зам, давааг засварлах ажилд зориулан 3.0 сая төгрөгийг журмын 2.1.1 дэх заалтаас,

3. Аймгийн онцгой байдлын хэлтэст өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах мөн автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс 44.3 сая төгрөгийг журмын 2.1.1 дэх заалтаас тус тус олгосон байна.

Харин Засаг даргын жуухын мөнгөн шагнал, буцалтгүй тусламж, хэвлэл захиалга, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, сургалт семинар, бусад гэх мэт зардлуудын санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

2.3. ТУХАЙН АРГА ХЭМЖЭЭ, ТӨСЛИЙГ ХАРИУЦАН ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГ ТОГТООСОН ХУГАЦААНД ИРҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

⁵ 4.2. Тухайн шатны Засаг даргын Тамгын газар төсвийн зардлын тооцоог Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/- ээр хянуулан холбогдох газар, хэлтсээс санал авч, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна

⁶ 4.3. Засаг даргын захирамжийг үндэслэн Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/ Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжигдэх арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно. Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн онцлогоос шалтгаалан эхний ээлжинд зарим бэлтгэл ажил /материал, түүхий эд бэлтгэх гэх мэт/ хийгдэх бол урьдчилгаа олгож болох бөгөөд урьдчилгааны хэмжээ нийт зардлын 30 хувиас хэтрэхгүй.

Журмын 4.5⁷ дахь заалтын хүрээнд авсан санхүүжилтийн тайлан холбогдох баримт материалаа аймгийн ЗДТГ-т 15 хоногийн дотор ирүүлэх ёстой. Харин аудитад хамрагдсан хугацаанд нийт 35 захирамжаар 106.5 сая төгрөгийн арга хэмжээнд санхүүжилт олгосноос 18 захирамжаарх арга хэмжээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл бүрэн гүйцэд байсан бөгөөд 17 захирамжаарх 71.8 сая төгрөгийн арга хэмжээний хэрэгжүүлсэн ажлын тайлан, АШБ байхгүй зөрчил илэрсэн ба аудитын явцад 13 захирамжийн 59.0 сая төгрөгийн арга хэмжээний хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлсэн тул аудитын явцад залруулсан бол 4 захирамжаар зарцуулсан 12.8 сая төгрөгийг арга хэмжээний ажлын тайланг гүйцэтгэгч байгууллагаас огт ирүүлээгүй байна.

/Хүснэгт-5/

Ажлын тайлан ирүүлээгүй арга хэмжээ		Үүнээс: аудитын явцад залруулсан нь		Залруулагдаагүй	
тоо	дүн /сая.төг	тоо	дүн /сая.төг	тоо	дүн /сая.төг
1	2	3	4	5=1-3	6=2-4
17	71.3	13	59.0	4	12.8

Цаашид журамд заасан хугацаанд арга хэмжээг зохион байгуулсан ажлын тайлан, холбогдох нотлох баримтыг гүйцэтгэгч байгууллагаас бүрдүүлж авах шаардлагатай байна.

2.4. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЛИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

Журмын 4.7⁸ дахь заалтын хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын 1 дүгээр гарын үсгийг аймгийн ЗДТГ-ын дарга, 2-р гарын үсгийг ЗДТГ-ын нягтлан бодогч зурж баталгаажуулан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаж үүрэгтэй. Аудитаар нийт 12 захирамжийн 48.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж зарцуулсан зөрчил илэрсэн. Үүнээс 9 захирамжийн 39.4 сая төгрөгийн төсөвийг зарцуулсан анхан шатны баримтын бүрдлийг аудитын явцад залруулсан. Харин 3 захирамжийн 8.8 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Үүнд:

1. Цаг тооны бичиг хэвлүүлсэн зардал гаргасан боловч анхан шатны баримт материалын бүрдэл дутуу 1.0 сая төгрөг.

⁷ 4.5. Тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

⁸ 4.7. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

2. Хангайн бүсийн идэрчүүдийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлж 0.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн ч ажлын тайлан нотлох баримт хангалтгүй.
3. 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах сэтгүүл хэвлэх зардалд 7.1 сая төгрөгийг гаргахаар санхүүжүүлсэн ч тайланд авлагаар бүртгээгүй.
4. Мөн аймгийн ЗДТГ-ын жижиг мөнгөн сангийн данс руу шагнал урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэлэг, дэмжлэг зэрэг санхүүжилт шилжүүлэн бэлнээр олгогддог бөгөөд эдгээр зардлуудын анхан шатны баримт материалын бүрдэл хангалтгүй дутуу байна. Ялангуяа засаг даргын нэрэмжит тэтгэлгийг оюутнуудад олгохдоо ЗДТГ-ын дансаар бус тухайн оюутны данс руу шилжүүлэх нь зүйтэй юм.

Иймд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримт материалыг хангалттай бөгөөд зохистой бүрдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Дүгнэлт:

Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн томоохон зардлын тооцоог СТСХ-ээр хянуулж, санхүүжилтийг олгож байгаа хэдийч анхан шатны баримтын бүртгэлээр тавих хяналт сул гүйцэтгэгч байгууллагаас журамд заасан хугацаанд ажлын тайланг ирүүлэхгүй байна.

Зөвлөмж:

- Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа тухайн арга хэмжээний төсвийн зардлын тооцоог аймгийн СТСХ-ээр хянуулж хэвших
- Журамд заасан хугацаанд арга хэмжээг зохион байгуулсан ажлын тайлан, холбогдох нотлох баримтыг гүйцэтгэгч байгууллагаас бүрдүүлж ажиллах
- Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитаас хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах дүгнэлтийг хийлээ.

БҮЛЭГ 1. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРИМ ЗАРЦУУЛАЛТ УРСГАЛ ШИНЖТЭЙ БАЙНА.

- 1.1. Засаг даргын нөөц хөрөнгийн ихэнх хувийг журмын 2.1.3 дахь заалтын хүрээнд зарцуулсан байна.
- 1.2. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг журмын 3.1-д заасны дагуу ЗД-ын зөвлөлийн хурлын шийдвэрээр зарцуулахгүй байна.
- 1.3. Засаг даргын нөөц хөрөнгийг аймгийн ИТХ-аар батлуулж ажилласан байна. .

БҮЛЭГ 2. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХДАА АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЛИЙГ БҮРЭН ХАНГАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

- 2.1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн томоохон зардлын хувьд тооцоог СТСХ-ээр хянуулан холбогдох газар хэлтсээс санал авсан байна.
- 2.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжигдэх зарим арга хэмжээг үе шатны ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан санхүүжилтийг олгосон байна.
- 2.3 Тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд ирүүлэхгүй байна.
- 2.4 Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах хэрэгтэй байна

Дээрх бүлгийн дүгнэлтүүдийг нэгтгэн дараах ерөнхий дүгнэлтийг өглөө.

НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛӨӨС ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Тайлан бичсэн: Аудитор
Аудитор

Г.Цог-Эрдэнэ
Х.Алтанчимэг

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

***Архангай аймгийн засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлэн захирагч
Ц.Мөнхнасан танаа***

1. Засаг даргын дэргэдэх зөвлөл нь журмын 3.1-д дахь заалтыг хэрэгжүүлж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах.
2. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, түүний төсөв тооцоонд тавих хяналтыг сайжруулж, журамд заасны дагуу ажлын тайлан, холбогдох нотлох баримтыг бүрдүүлж хэвших.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлснээр Засаг даргын нөөц хөрөнгө үр ашиггүй, хяналтгүй, тооцоо судалгаагүй зарцуулагдахаас сэргийлэгдэж, цаашид анхан шатны бүртгэлээр тавих хяналт сайжирна гэж үзэж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 02 сарын 25-ны дотор холбогдох нотлох баримтын хамт Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.